




Digital Brochure



STUDY & ENJOY
FOR YOUR SUCCESS

СЭБҮ

ФИЛИППИН УЛСЫН ТУХАЙ

Филиппин бол Европ, Америк болон Азийн амьдралын хэв маяг, соёлыг хослуулан шингээсэн Ази дахь цорын ганц католик, ислам мөн буддын шашин зонхилсон улс юм.

Филиппин улс нь 7107 арлаас бүрддэг бөгөөд Магелланы бүлэг 1521 онд суурьшин ирснээр үүссэн. 350 жил Испанийн эрхшээлд байсан ба 50 жилийн турш Америк улсын колони, дэлхийн 2-р дайнд Япон улсын эрх мэдэлд байснаар 1946 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж Бүгд Найрамдах Филиппин улсыг байгуулсан. Энэхүү он удаан жилийн түүхээс улбаалан соёл, амьдралын хэмнэл, барилга байгууламж зэрэг нь Европ, Америк болон Японы хосолсон хэв маягтай болсон. Мөн Ази тивийн цорын ганц католик шашинтай улс юм. Филиппин улс нь англи хэл хамгийн ихээр хөгжсөн гэдгээрээ мөн дэлхийд алдартай.

Улс : Бүгд Найрамдах Филиппин улс

Нийслэл : Манила

Хүн Ам : 114 сая (2021)

Сэбү хот- 5 сая

Албан ёсны хэл : Англи/ Филиппин

Уур амьсгал : Далайн эргийн халуун бүс

Дундаж цаг агаар : 27~29°C

Мөнгөний нэгж : Филиппин песо

Цагийн бүс : Монгол Улстай нэг цагийн бүсэд оршдог



Филиппин улс нь Англи хэлээр ярьдаг хүн амын тоогоороо дэлхийн гурав дахь том улс юм.

Филиппин хэл нь албан ёсны хэл ч гэсэн бүс нутгаараа өөр өөр хэл ашигладаг. Жишээ нь Сэбү хотод Сэбүан хэлээр ярьдаг тул Англи хэлийг үндсэн хэл болгон ашигладаг. 2014 онд Филиппин улсын хүн ам 100 сая хүрснээр англи хэлээр ярьдаг улсын жагсаалтад Англи, Америк улсын дараагаар бичигдэх болсон. Мөн Филиппин улс нь бизнес англи хэлний мэдлэгээрээ дэлхийд тэргүүлж байна хэмээн 2013 онд бичигдсэн байдаг.



ЯАГААД ФИЛИППИН ГЭЖ

Өвөрмөц бөгөөд сонирхолтой ганцаарчилсан хичээлийн программуудтай. Гадаадад суралцах хамгийн хэмнэлттэй улс бол яах аргагүй Филиппин юм.

Европ, Америк улс нь гадаадад суралцах зах зээлд ноёрхсон хэвээр байгаа бөгөөд Өмнөд Америк, Европ, мөн Далайн орнууд уг зах зээлийн 80%-ийг эзэлдэг. Үүнтэй зэрэгцэн Ази тивийн Филиппин, Сингапур, Хятад, Өмнөд Солонгос болон Тайван улсууд тус зах зээлийн бараг 20%-ийг эзлээд байна. Энэ дундаас Филиппин улс нь Англи хэлний сургалт болон суралцагчийн тоогоороо 2010 оноос хойш эрчимтэй илүүрхэж байгаа. Учир нь хүмүүс гадаадад суралцахдаа сургалтын чанар, үнэ өртөг болон хичээлийн программууд дээр анхаардаг тиймээс Филиппин улс нь бүх насныхны суралцах нөхцөл, аюулгүй орчноор хангаж өгснөөр алдартай болж чадсан.

ЯАГААД СЭБҮ ХОТ ГЭЖ

Сэбү хот нь Филиппин улсын хоёр дахь том хот бөгөөд Ази тивийн алдартай амралт жуулчлалын бүс учир олон жуулчдыг татдаг.

Сэбү аймаг нь 167 арлаас бүрддэг бөгөөд Сэбү хот арлын гол хэсэгт хойд зүгээс урагшаа нарийхан сунаж байрладаг. Тус газар нь орчин үеийн байгууламж бүхий олон тооны амралтын газруудтай бөгөөд Филиппиний зуны амралтаа өнгөрөөх шилдэг газруудын нэг гэдгээрээ алдартай. Тэдгээрийн дотроос “Өмнөдийн хатан хаан” хочтой Сэбү арлын төв болох Себу хот нь Манилагийн дараа орох хоёр дахь том хот юм. Сэбү нь Филиппиний хамгийн эртний хотын түүхтэй бөгөөд арал дээрх олон барилга байгууламж, хөшөө дурсгалууд түүний түүхийг гэрчилдэг.



GLC
GLOBAL LANGUAGE CENTRE

Digital Brouchure



GLC-ИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ



GLC-ИЙН ТУХАЙ



Global LAnguage Cebu байгууллага нь 2011 онд 80 оюутантай англи хэлний сургалтын төвөөр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан. Өдгөө 2024 оны 5-р сарын байдлаар тус сургууль нь өргөжин тэлж 600 гаруй оюутан хүлээн авах чадалтай Филиппин улсын хамгийн том сургуулиудын нэг болоод байна. Одоогийн байдлаар GLC-д олон улсын өөр өөр үндэстний оюутнууд Ази, Европ болон Өмнөд Америкаас ирж суралцсаар байна. Даяаршиж байгаа нийгэмд, бизнес төдийгүй өдөр тутмын амьдралд англи хэлний шаардлага гарч байгаа учир олон хүмүүс уг сонголтыг хийж манай сургуульд ирж байна.

GLC нь 10000 гаруй олон улсын оюутныг англи хэлний хөтөлбөрт хамруулсан тул Филиппин улсын Сэбү хот даяаршлын эхлэлийн цэг болж чадна гэж итгэж байна. Зарим хүмүүс эх орондоо амьдран суурьшиж байхад зарим хүмүүс дэлхийтэй хөл нийлүүлэн алхахаар бидэнтэй нэгдэж байна. GLC нь таны англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх үндэс болно.

Дэлхийн жишигт нийцсэн хэлний сургуулийн хувьд GLC нь та бүхний боловсролыг дэмжихийн тулд тоног төхөөрөмж, суралцах хөтөлбөрөө үргэлж хөгжүүлдэг билээ. Бид бага балчраас ахмад настан хүртэл бүх насны, олон улсын оюутнуудад үр дүнтэй, утга учиртай суралцах, туршлага хуримтлуулах орчныг бүрдүүлэх болно.



ДОТУУР БАЙР

ХАМГИЙН ШИЛДЭГ НЬ GLC

GLC-ийн үндсэн зарчим бол “СУР бас ХӨГЖИЛД.”

GLC-ийн зорилго бол СЭБҮ дахь хамгийн шилдэг Англи хэлний сургууль болох.

GLC нь танд гадаадад суралцах хугацаандаа үр дүнтэй цагийг бүтээхэд тань бүх талаар дэмжиж олон боломжуудаар хангах болно. Энэ нь та зөвхөн "суралцах" төдийгүй "хөгжилдөх" замаар англи хэлээ хөгжүүлж, мэдлэгээ дээшлүүлэх боломжтой гэсэн үг юм. Бид усан спорт, сайн дурын ажил гэх мэт янз бүрийн нийгмийн үйл ажиллагаа зохиодог бөгөөд энэ үеэр шинэ найз нөхөдтэйгөө болох, олон зүйлийг шинээр мэдэх боломжийг олгодог.



БҮГД НЭГ ДОР ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ТУСЛАМЖ



Сургууль

Сургууль болон дотуур байр хамтдаа учир аюулгүй.



Дотуур байр

Өрөөний 3-н төрлийн сонголт (Нэг ор/ Хоёр ортой/ Гурван ортой) эрэгтэй, эмэгтэй тусдаа давхарт байрладаг.



Өдрийн гурван хоолттой

Бид олон улсын хоолуудыг буфет хэлбэрээр бэлтгэдэг.



Туслах ажилчин

10 орны менежерүүд танд өөрийн хэлээр тусламж авахад тусална.



Өрөөний цэвэрлэгээ болон хувцас угаалга


Өрөөний цэвэрлэгээг долоо хоногт нэг удаа, хувцас угаалгыг бид долоо хоногт 2 удаа хийнэ.



Сургуулийн сувилагч/ Эмнэлгийн үйлчилгээ

Долоо хоног бүр эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг мөн сургуульд сувилагч болон анхан тусламжийн бүх зүйлс байгаа.

GLC-ИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Хаяг: New Frontier Mabolo Cebu City, Cebu, Philippines 6000

Үүсгэн байгуулагдсан огноо: 2011 оны 10-р сар
Одоогийн байрандаа 2022 оны 11-р сард нүүж ирсэн.

Хүчин чадал: 600 хүн

Байгууламж: Ганцаарчилсан хичээлийн өрөө, олноор хичээллэх анги, саруулхан танхим, хооллох хэсэг, оюутнуудын чөлөөт цагийн өрөө, хоолны газар, хүүхдийн өрөө, анхан тусламжийн өрөө, фитнес, ширээний теннис, тоглоомын өрөө, залбирлын өрөө, сагсны талбай, үнэгүй Wi-Fi, гэх мэт

Ажилчид: Филиппин, Япон, Тайван, Хятад, Солонгос, Тайланд, Орос, Монгол, Иордан, Вьетнам орны ажилчидтай.

GLC-ийн эргэн тойрон дахь орчин: Том худалдааны төв, дэлгүүр, кофе шоп, массажны газар, эмийн сан, жуулчны бааз, усан сан, эмнэлэг гэх мэт бүгд байгаа

GLC-ИЙН ДОТУУР БАЙР



Хөл хорионы цаг: 23:00

Тавилга: Сандал, Ор, Агааржуулагч, Хувцасны шүүгээ, Халуун ус, Нойл, Хөргөгч, Үс хатаагч, Сэнс, Ус буцалгагч, Хөшиг, Үнэгүй Wi-Fi.

Барилга дотор / өрөөний төрөл: Нэг ортой / Хоёр ортой / Гурван ортой

Буудалд / өрөөний төрөл: Нэг ортой / Хоёр ортой

СУРАЛЦАХ СИСТЕМ

СУРГАЛТЫН АРГА БАРИЛ

Харилцааны арга барил

Англи хэлний үгийн баялагаа сайжруулахад тань GLC-н үе шатлалтай харилцан ярианы программ туслана.

Нэмэлтээр логик ярианы PREP болон сонсголын RRR аргуудыг нэгтгэснээр суралцах аргыг илүү хурдан болгосон.

Мөн гадаад оюутнуудын ангид ярианы хэмжээг хянах барометрийг байрлуулсан. Бид олон улсын оюутнууд болон багш нарын ярианы харьцааг 7:3 байх олон улсын дүрмийг ашигласнаар оюутнуудад англиар ярих боломжийг дээд зэргээр нэмэгдүүлсэн.



Логик яриан дээр тулгуурлан бэлдэх PREP арга



Олон улсын тоастмастерс арга нь ойлгомжтой, логиктой ярианы үндэс болдог учир уг аргыг бид санал болгодог. Эхлээд өөрийнхөө үзэл бодлыг бичиж, тайлбарлах. Дараагаар нь шалтгааныг өгөгдөл эсвэл жишээгээр дэлгэрүүлэх. Энэ нь танд санаагаа бүрэн илэрхийлэх чадварыг өгөх бөгөөд мөн бусад хүмүүс таныг ойлгох боломжийг бүрдүүлж өгч байгаа юм:

RRR сонсголын арга




Идэвхтэй сонсох нь ярианы хэмнэлийг барих арга техник юм. Энэ бол нөгөө хүнийхээ яриаг сайн ойлгох, харилцан яриаг идэвхтэй болгож дэмжих, динамик сонсох арга юм. Бид зүгээр л сонсох юм уу, чимээгүй байхын оронд хариу үйлдэл үзүүлж, асуулт асуух, санал бодлоо хуваалцах замаар сэдвийг өргөжүүлж, идэвхтэй харилцааг хөгжүүлснээр эерэг харилцааг мөн бий болгож чадаж байгаа юм.



Digital Brochure

QR-ыг уншуулаад GLC-ийн талаар илүү их мэдээллийг аварай.

ТҮВШИН ИЙ АНГИЛАЛ



GLC нь оюутнуудад хэлний түвшинд нь тохирсон 12 шатлалтай хөтөлбөрийг санал болгодог. GLC нь олон улсын CEFR стандартад нийцсэн мөн дэлхийн боловсролын байгууллагуудын баталсан түвшний схемийг баримталдаг. Энэ нь танд англи хэлний мэдлэгээ дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц стандартаар сурах боломжийг олгоно.

CEFR гэж юу вэ?

CEFR (Европын хэл сурах түгээмэл зөвлөмж: сурах, заах, үнэлэх) нь гадаад хэл сурах зөвлөмж материал юм. Энэ нь дэлхий нийт боловсролын байгууллагуудын баталсан хэлний түвшний үнэлгээний олон улсын стандарт юм. 38 төрлийн хэл болон англи хэлийг түвшингээр ангилах боломжтой. CEFR нь нийт 6 түвшинтэй бөгөөд A1 / A2 түвшин нь үндсэн шат, B1 / B2 нь бие даах чадварын үе шат, C1 / C2 түвшин нь ахисан шат юм. Уг шатлал нь уламжлалт түвшний хэл зүй, үгийн сан, хэлний утга дээр тулгуурлан дүгнэгдсэн. CEFR нь мэдлэг, практикаар үнэлэгддэг түвшний ангилал юм.



СУРГАЛТ

СУРАХ МАТЕРИАЛ

Сургалтын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд цахим сургалтыг нэвтрүүлсэн.



GLC нь SDG программыг нэвтрүүлэн ашигладаг. Манай дижитал сургалтын материалууд сургалтын үр дүн өндөртэй, агуулга нь ойлгоход хялбар, цаасан материалаас илүү онлайн байх нь оюутнууд бие даан суралцахад түлхэц болдог.



ӨДӨР ТУТМЫН ТОГТМОЛ ХУВААРЬ

Энэ хуваарь нь жишээ бөгөөд хуваарь тус тусдаа өөрчлөгдөж болно.

Цаг	Хуваарь
7:30 - 9:00	Өглөөний цай
8:00 - 8:50	Групп хичээл (1)
9:00 - 9:50	Ганцаарчилсан хичээл (1)
10:00 - 10:50	Завсарлагаа
11:00 - 11:50	Ганцаарчилсан хичээл (2)
12:00 - 12:50	Өдрийн хоол
13:00 - 13:50	Ганцаарчилсан хичээл (3)
14:00 - 14:50	Групп хичээл (2)
15:00 - 15:50	15:00-15:25 Тусгай нэмэлт анги 1 15:30-15:55 Тусгай нэмэлт анги 2
16:00 - 16:50	Ганцаарчилсан хичээл (4)
17:00 - 17:50	Завсарлагаа
18:00 - 18:50	Оройн хоол
19:30 - 20:50	Бие даан суралцах цаг



YouTube

Албан ёсны YouTube суваг

Power Speaking ESL- Ярианы анги

- ▶ Анхан шат ~
- ▶ 15-с дээш нас
- ▶ Даваа гараг бүр
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр

Light Power Speaking : MTM3 + GRP2 + OP

Power Speaking : MTM4 + GRP2 + OP

Intensive Power Speaking: MTM5 + GRP2 + OP

Ultra7 Power Speaking : MTM7 + GRP1 + OP

Энэ нь англи хэлний анхан шатнаас ахисан түвшний суралцагчдад зориулсан ерөнхий англи хэлний хөтөлбөр юм. Тус анги нь практик дээр тулгуурласан сургалтын хөтөлбөрөөс бүрддэг. Та яриа, дуудлага, асуултад хурдан хариулах арга зэрэг сэдвүүдийг судалж бодит амьдрал дээр ярих шаардлагатай нөхцөлд ашиглах ярианы чадварыг эзэмших боломжтой.

ГЭР БҮЛД ЗОРИУЛСАН АНГИ

- ▶ Анхан шат ~
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр
- ▶ Даваа гараг бүр
- *Групп анги : 15-с дээш нас

Family Package 2 : MTM8 + GRP2 + OP

Family Package 3 : MTM12 + GRP2 + OP

Family Package 4 : MTM16 + GRP2 + OP

Гэр бүлээрээ гадаадад суралцах боломжийг манай гэр бүлийн багц танд олгож байна. Энэхүү 2, 3, 4 багц нь ганцаарчилсан хичээлийн тооны харьцааг гэр бүл, эцэг эхтэйгээ хуваалцан суралцахад зориулагдсан. Гэр бүлийн 2-4 гишүүн (хэрвээ хүүхэд 15- аас дээш настай бол) ерөнхий англи хэлний хөтөлбөр (Power Speaking Course)-т болон групп хичээлд хамрагдах боломжтой. Хэрэв 5-14 насны хүүхдүүдтэй бол Kids болон Junior English хөтөлбөрийг суралцах бөгөөд үүнд групп анги байхгүй зөвхөн ганцаарчилсан ангид суралцана.

Гэр бүл, эцэг эхтэйгээ хичээлээ хуваалцан суралцах боломжийг олгодог багц.

Энэхүү хөтөлбөрт нь гадаадад хэл суралцаж буй гэр бүл, эцэг эх, хүүхдүүдэд 3 нь багцын сонголттойгоор хичээлүүдийг хуваалцах боломжийг олгодог. Хуваалцах хүмүүсийн тоо 2-4 бөгөөд гэр бүлийн гишүүн эсвэл эцэг эх мөн хүүхэд нь байх ёстой. Хэрэв 15-с дээш насны хүүхэдтэй бол ганцаарчилсан болон групп хичээлийн нэг хүнд ноогдох тооны харьцааг сонгох боломжтой.

Та хүссэн үедээ хичээлийн цагаа гэр бүлдээ шилжүүлж Сэбү хотыг үзэж аялах боломжтой.

Та энд байх хугацаандаа хүүхдийнхээ түвшнээс хамаарч гэр бүл дундаа хүссэн хугацаандаа хичээлийн харьцааг солих боломжтой. (Гэхдээ 3-р, 7-9-р саруудад ачаалал ихтэй үед боломжгүй байж магадгүй.) Эцэг эхчүүд хүүхдүүддээ хичээлийн хуваарийг нь төлөвлөж өгөх мөн хамтдаа гадуур зугаалж, дэлгүүр хэсэх боломжтой.

MTM : Ганцаарчилсан хичээл GRP : Групп хичээл OP : Нэмэлт хичээл

СУРГАЛТ



Digital Brochure

QR-ыг уншуулаад GLC-ийн талаар илүү их мэдээллийг аваарай.

Kids English Junior Power Speaking

- ▶ Анхан шат ~
- ▶ Даваа гараг бүр
- ▶ 5-11 нас Kids English
- ▶ 12-14 нас Jr Power Speaking
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр

Kids English 6 (5-11) : **MTM6**
Kids English 7 (5-11) : **MTM7**
Kids English 8 (5-11) : **MTM8**
Junior Power Speaking 6 (12-14) : **MTM6**
Junior Power Speaking 7 (12-14) : **MTM7**
Junior Power Speaking 8 (12-14) : **MTM8**

Энэхүү курс нь 5-14 насны хүүхдүүд болон өсвөр насныханд зориулсан англи хэлний анги юм. Англи хэл сурч эхэлж байгаа 5-11 насны хүүхдүүдэд сургууль дээрээ сурах боломжгүй хичээлүүдийг ганцаарчилсан ярианы ангиар дамжуулан сурах боломжтой. Бид багштайгаа бичлэг үзэх, дуу сонсох маягаар сонирхолтой хичээлийн программуудыг боловсруулсан. Энэхүү анги нь гадаадад суралцахаар төлөвлөж байгаа бага ангиас эхлээд дунд анги хүртэлх ангийн хүүхдүүдэд тохиромжтой.

TOEIC

- ▶ Lv.4-с дээш (A1.3)
- ▶ Сар бүрийн 2 дахь болон 4 дахь Даваа гараг
- ▶ 15-с дээш нас
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр

General TOEIC : **TOEIC MTM4** + **GEGRP2** + **OP**
Intensive TOEIC : **TOEIC MTM5** + **GEGRP2** + **OP**
Ultra8 TOEIC : **TOEIC MTM8**

Уг хөтөлбөрөөр та эрчимжүүлсэн 7 хоногийн ангид ч хамрагдах боломжтой. Эрчимжүүлсэн анги нь таны ахисан ерөнхий мэдлэгт тулгуурлан TOEIC-ийн унших, бичих, ярих чадварыг сайжруулна. Мөн нэмэлтээр ерөнхий англи хэлний групп хичээлд хамрагдана.

TOEIC-ийн оноо авахаар зорьж буй хүмүүст зориулж өдөр 8 удаагийн ганцаарчилсан хичээлтэй багцыг (Ultra 8) мөн санал болгодог. Сургалтын материалын хувьд бид TOEIC-ийн цахим сургалтын хичээлүүдийг ашигладаг бөгөөд ингэснээр та хичээлээс гадуур бие даан суралцаж, тестүүд дээр ажиллах боломжтой.

IELTS

- ▶ Lv.4-с дээш (A1.3)
- ▶ Сар бүрийн 1 дэх болон 3 дахь Даваа гараг
- ▶ 15-с дээш нас
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр

General IELTS : **IELTS MTM4** + **GEGRP2** + **OP**
Intensive IELTS : **IELTS MTM5** + **GEGRP2** + **OP**
Ultra8 IELTS : **IELTS MTM8**

Энэ хөтөлбөрт мөн адил 7 хоногийн эрчимжүүлсэн ангид ч суралцах боломжтой. Эрчимжүүлсэн ангид IELTS-ийн ахисан ерөнхий англи хэлний хичээлүүдийг ганцаарчилсан ангид үздэг мөн групп хичээлээр ерөнхий мэдлэгийн хичээлийг судалдаг.

Мөн IELTS-ийн оноо авахаар зорьж буй хүмүүст зориулсан өдөрт зөвхөн ганцаарчилсан 8 хичээлд суух боломжтой Ultra 8 ангийн сонголт байгаа. Заах материалын хувьд бид IELTS-ийн цахим сургалтын материалын ашигладаг бөгөөд ингэснээр та хичээлийн бус цагаар бие даан бэлдэх мөн онлайн тестээр өөрийгөө шалгах боломжтой.

Бизнес англи хэл

- ▶ Lv.5 дээш (A2)
- ▶ Даваа гараг бүр
- ▶ 18-с дээш нас
- ▶ 7 хоногоос дээш хөтөлбөр

Business : **Business MTM4** + **GEGRP2** + **OP**
Ultra7 Business : **Business MTM7** + **GEGRP1**

Гадаадад ажил хийхээр зорьж байгаа болон англи хэл шаардлагатай ажлын байранд ажиллаж байгаа хүмүүст зориулсан хөтөлбөр юм. Хэрэв танд дээрх шаардлагын аль нэг нь тулгараад байгаа бол бид танд ганцаарчилсан болон групп хичээлийг санал болгож байна. Энэхүү хөтөлбөрөөр та унших, бичих, ярих болон сонсох чадваруудаа жигд сайжруулах боломжтой. Мөн бизнест ашиглагдах үгсийн сангаа сайжруулж, уулзалт, илтгэл, хэлэлцээр хийх чадваруудыг эзэмшинэ.

Бизнес англи хэлний анги нь таныг бизнес уулзалт, худалдаа наймааны хэлэлцээрийн явцад санаагаа зөв оновчтой гаргахад тань тусална. Уг сургалтаар та ярих, өөрийгөө илэрхийлэх чадвараа сайжруулахаас гадна энтрепренёр сэтгэлгээгээ нэмэгдүүлнэ.

MTM : Ганцаарчилсан хичээл GRP : Групп хичээл
TOEIC MTM : TOEIC-ийн ганцаарчилсан
IELTS MTM : IELTS-ийн ганцаарчилсан
Business MTM : Бизнес ганцаарчилсан
GEGRP : Ерөнхий англи хэлний групп хичээл
OP : Нэмэлт хичээл

Cambridge CELTA

Тун удахгүй





Authorised Exam Centre

ЗУРАГ



Digital Brochure

QR-ыг уншуулаад GLC-ийн талаар илүү их мэдээллийг аваарай.



STUDY ENJOY

LEARN MORE ABOUT



JAN

S	M	T	W	T	F	S
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

FEB

S	M	T	W	T	F	S
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	

MAR

S	M	T	W	T	F	S
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31					

APR

S	M	T	W	T	F	S
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30			

MAY

S	M	T	W	T	F	S
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

JUN

S	M	T	W	T	F	S
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30					

JUL

S	M	T	W	T	F	S
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

AUG

S	M	T	W	T	F	S
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						

SEP

S	M	T	W	T	F	S
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				

OCT

S	M	T	W	T	F	S
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

NOV

S	M	T	W	T	F	S
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30						


DEC

S	M	T	W	T	F	S
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

- Red Color : No Class
- Yellow Mark : Special Group Session

2025 Weekend Activity



January Jan 11th Oslob & sumilon Jan 25th Island hopping 	February Feb 8th Oslob & waterfall Feb 22nd City tour 	March Mar 8th Oslob & sumilon Mar 22nd Island hopping
April Apr 12th Oslob & waterfall Apr 26th Island hopping	May May 10th Oslob & sumilon May 24th Study tour	June Jun 14th Oslob & waterfall Jun 28th City tour 
July Jul 5th Oslob & sumilon Jul 12th City tour Jul 19th Island hopping Jul 26th Study tour	August Aug 9th Oslob & waterfall Aug 16th City tour Aug 23th Island hopping Aug 30 Study tour 	September Sep 13th Oslob & sumilon Sep 27th City tour 
October Oct 11th Oslob & waterfall Oct 25th Island hopping 	November Nov 8th Oslob & sumilon Nov 22nd City tour	December Dec 13th Oslob & waterfall Dec 23rd Christmas party Dec 27th Island hopping



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Digital Brochure
More details about GLC

 **Instagram**



 **YouTube**

